

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг
сэтгүүлчдэд танилцуулах сургалт семинар**

2011 оны 9 дүгээр сарын 9

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Л.ПҮРЭВДОРЖИЙН ҮГ

Эрхэм хүндэт сэтгүүлчид ээ!

Юуны өмнө цаг зав гарган энд хүрэлцэн ирсэн та бүхэнд чин сэтгэлээсээ талархлаа илэрхийлье. Миний бие Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдсноос хойш Төв банкны үйл ажиллагааг сэтгүүлчдэд нээлттэй, ил тод болгохыг тууштай дэмжсээр ирсэн билээ. Монгол улс зах зээлийн эдийн засгийн замыг сонгоод даруй 20 жил болж байна. Цагийн өндөрлөгөөс эргэн харахад сэтгүүлчид та бүхэн мөнгөний бодлогыг зөв томъёолох, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж ирсэн гэдэгтэй өнөөдөр маргах хүн гарахгүй биз ээ. Ийм ч учраас Монголбанк та бүхэнтэй хамтран ажиллахад онцгой ач холбогдол өгч байгааг цохон тэмдэглэж байна.

Энэ ажлын нэг хэсэг болгон бид анх удаа Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг сэтгүүлчид та бүхэнд танилцуулан олон нийтэд хүргэх санал бодлыг тань сонсохоор энд цуглараад байна. Жил бүрийн 10 дугаар сарын 1-нээс өмнө “Төв банкны тухай” хуулийн дагуу Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барьдаг билээ. Энэхүү баримт бичгийн ач холбогдлыг дутуу үнэлэх аргагүй юм. Түүнд Монголбанкны дараа жилийн зорилтууд төдийгүй өмнөх оны мөнгөний бодлогын хэрэгжилт тусгалаа олдог билээ. Монголбанкнаас өргөн барьсан төслийг УИХ-ын гишүүд хэлэлцэж нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж эцэслэн баталдгийг та бүхэн мэднэ.

Үндсэн чиглэлийн хүрээнд 2012 онд Монголбанкнаас хийж гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлуудыг манай захирлууд дэлгэрэнгүй танилцуулах тул би хамгийн чухал гэсэн хэдэн санааг цухас дурьдъя.

Юуны түрүүнд бид ирэх жилийн ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляцийг нэг оронтой тоонд буюу 10-аас доош хувьд барихаар саналаа оруулж байгаа. 10 хувийн инфляци нь хэдийгээр өндөр талдаа байх ч манай өнөөдрийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд үүнээс нам зорилт дэвшүүлэх боломжгүй байна. Төв банк инфляцийг ийм түвшинд хязгаарлаж цаашид намсгах зорилго тавьж байна.

Ханшийн хувьд бол зохицуулалттай хөвөгч ханшийн бодлогоо үргэлжлүүлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Өөрөөр хэлбэл, төгрөгтэй харьцах валютын ханшийг эдийн засгийн суурь хүчин зүйлс тодорхойлсон хэвээр байх бөгөөд Монголбанкны оролцоо нь зөвхөн огцом савалгааг зөөлрүүлэх интервенцээр хязгаарлагдах болно.

Санхүүгийн тогтвортой байдлын тухай асуудал дэлхийн төв банкуудын онцгой анхааралд байгааг та бүхэн анзаарсан байх. Бид ч ялгаагүй манай санхүүгийн секторыг дангаараа бүрдүүлж байгаа банкны секторын эрүүл мэндэд онцгой анхааран ажиллаж байна. Санхүүгийн салбарыг чадавхижуулах макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч буй нь энэ жилийн онцлог юм.

Монголбанк мөнгөний бодлогын зорилт, хэрэгсэл, хэрэгжилтийн явцыг цаашид ч олон нийтэд улам ил тод, нээлттэй байлган нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа дээшлүүлж, Төв банкинд итгэх итгэлийг лавшруулахын төлөө ажиллах болно.

Одоо мөнгөний бодлогыг тойрон ойрын үед яригдаж болзошгүй зарим нэг асуудалд та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна.

Нэгдүгээрт, инфляци болон эдийн засгийн өсөлттэй холбоотой асуудал байна. Зарим эдийн засагч, улс төрчид Монголбанк дан ганц инфляцийг л зорилтоо болгодог, эдийн засгийн өсөлтийг хөсөр хаядаг хэмээн олон нийтийн тархийг угаах гэж хичээж байна. Энэ бол маш буруу ойлголт гэдгийг цохон тэмдэглэхийг хүсч байна. Үнийн тогтвортой байдал нь хадгаламж, хөрөнгө оруулалт, бүтээмжээс олох хожоог урамшуулах бөгөөд тэдгээр нь эдийн засгийн өсөлтийн салшгүй хэсэг юм. Үүгээр зогсохгүй, тогтвортой бага инфляци нь орлогын хувиарлалт талаасаа ч тустай зүйл юм, учир нь ажил эрхлэлтийн тогтвортой өсөлтийг тэтгэхийн дээр нийгмийн эмзэг бүлгийнхний бодит орлогыг хамгаалж байдаг.

Хамгийн ойрын жишээг татъя: оюутнуудын энэ жилийн сургалтын төлбөр 10 орчим хувиар нэмэгдсэн байна, зарим их дээд сургууль үүнээс ч илүү нэмэхээр байсан ч БСШУЯ-наас хориглосон байгаа. Энэ юутай холбоотой вэ? Үүнд өнөөх л инфляци буруутай. Хэрвээ сургалтын төлбөр энэ янзаар нэмэгдээд байвал оюутны тоо, чанарт сөргөөр нөлөөлөхгүй гэж үү? Энэ нь эргээд ирээдүйн ДНБ-ний хэмжээг бага байлгахад нөлөөлөхгүй гэж үү?

Та бүхэн Улаанбаатарын замыг хаа сайгүй засч, засварлаж байгааг нүдээр үзэж байгаа. Гэтэл зарим зам засварын ажил гэнэт зогсох жишээг бид харж л байсан. Яагаав гээд лавлахаар тендер шалгаруулах үеийн төсөв инфляциас болоод хэтэрсэн, мөнгө хүрэлцэхээ байсан тул арга буюу сул зогсож байна гэсэн тайлбар өгдөг. Инфляциас болоод зам тавигдсангүй, гэтэл зам тавихгүй бол ДНБ өсөх боломжтой юу? Ингээд тоочоод байвал дуусахгүй. Инфляци эдийн засгийн өсөлтөд ямар чухал зүйл болохын хоёрхон жишээ нь энэ.

Эндээс бид инфляцийг бага байлгахын тулд л бага байлгахаар зорьдог юм биш гэдэг нь харагдаж байна. Төв банкны энэхүү үндсэн зорилт нь эцсийн дүндээ бодит секторын эрүүл, тогтвортой өсөлтийг ханган иргэдийн амьдралыг тууштай дээшлүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Бидэнд бодит өсөлт авчирдаггүй, зөвхөн үнийн хөөсийг л дагуулах эдийн засгийн хэт халалт хэрэггүй, эрэлт хэт хумигдсанаас үүдэлтэй эдийн засгийн уналт бүр ч хэрэггүй. Өөрөөр хэлбэл, бидэнд савалгаагүй, тогтвортой, он удаан жил үргэлжлэх тийм л эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн мөнгөний бодлого хэрэгтэй. Хурдацтай л байвал сайн гэсэн ойлголт юунд хүргэж болохыг 2008-2009 оны хямрал бидэнд тод харуулсан гэж бодож байна. Саяхан бид бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар өсгөхдөө бодит секторын үйлдвэрлэлийн хүчин чадал, инфляцийн хүлээлт гээд олон хүчин зүйлсийг харгалзан үзсэн. Хар ухаанаар бодоход 70%-ийн мөнгөний нийлүүлэлт болон 15%-ийн ДНБ-ний өсөлт хоёрын зөрүү инфляцийн дарамтыг өсгөхөөр байгаа нь илт биш гэж үү? Ингээд бодлогын хүүгээ нэмэх нь зүйтэй юм байна, эс бөгөөс инфляци өсч эдийн засгийн галт тэрэг төмөр замаасаа гарах эрсдэл лавширна гэж үзсэн.

Хоёрдугаарт, зээлийн хүүний асуудал байна. Зарим эдийн засагч Монголбанк бодлогын хүүгээ өсгөсөн тул одоо банкуудын зээлийн хүү өсөн нэмэгдэнэ хэмээн шүүмжилж байгаа. Гэхдээ энэ нөхцөл байдлыг та бүхэн арай өөр өнцгөөс харахыг хүсч байна. Төв банк улс төрийн дарамт, шахалтаас айн хүүгээ нэмэлгүй зүгээр суувал юу болох бол? Эдийн засгийн хүчин чадлаас хэтэрсэн мөнгөний нийлүүлэлт нь үнийн өсөлтөөр дамжин хэт халалтыг бий болгоно. Харин инфляци нэг өсөөд эхлэх юм бол, өөрөөр хэлбэл инфляцийн хүлээлтэд нөлөөлж хоёр дахь үеийн доргиог үүсгээд эхэлбэл

хадгаламжийн хүү ч тэр, зээлийн хүү ч тэр өсөөд эхлэх нь гарцаагүй. Хадгаламжийн хүүний, зээлийн хүүний дийлэнхийг инфляцийн хүлээлт бүрдүүлж байна шүү дээ. Иймээс ирээдүйд хүүг хэт өндөр түвшинд хүрэхээс сэргийлж өнөөдөр бодлогын хүүгээ өсгөж байна. Та бүхэнд хандаж хамтдаа инфляцитай тэмцэж, ингэснээр зээлийн хүүгээ бууруулья гэж уриалж байна! Бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж буйн төлөө бизнес эрхлэгчдийг буруутгахаас өмнө инфляцийн цаад учир шалтгааныг хамтдаа олж, улс төрчид, Засгийн газрын анхаарлыг үүнд хандуулж чадах юм бол “үнийн өсөлтийн мангаснаас” манай эдийн засаг ангижрах боломжтой болно.

Гуравдугаарт, эдийн засагт “цаг хугацааны нийцгүй байдал” гэсэн ойлголт байдаг. Өдөр тутмын зорилтуудыг урьтал болгосноор урт хугацааны үндсэн зорилтуудаа алдах тухай ойлголт юм. Манай улсын хувьд мөнгөний бодлогын арга хэмжээний үр дүн 0.5-1 жилийн дараа мэдрэгддэг. Эндээс мөнгөний бодлого урагшаа харах, ирээдүйд үүсч болох эрсдлүүдийг урьдчилан тооцох шаардлагатай нь харагдана. Ийм ч учраас мөнгөний бодлогыг богино хугацааны асуудлыг шийдвэрлэхэд бус харин урт хугацааны үр дагаварт чиглүүлэх нь зөв байдаг. Богино хугацааны зорилт урт хугацааны зорилттой зөрчилдөх нэг жишээг татъя: улс төрчдийн шахалтаар төв банк мөнгөний нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлээ гэж саная. Богино хугацаанд энэхүү арга хэмжээний үр дүнд үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, ажилгүйдэл буурах боломжтой. Гэвч урт хугацаанд цалин, үнэ нэмэгдсэнээр бүтээгдэхүүний хэмжээ өсөхгүй төдийгүй ажилгүйдлийн түвшин ч буурахгүй. Харин үнийн өсөлт гаарч, урт хугацаанд эдийн засгийн уналтыг авчрах эрсдэлтэй болно. Сонгууль дөхөж байгаа тул Монголбанкийг популист өнцгөөс шүүмжлэх, ялангуяа мөнгөний нийлүүлэлтийг эрс нэмэгдүүл хэмээн шаардах хүн олон гарах байх, гэхдээ та бүхэн Төв банкны арга хэмжээг зөвөөр ойлгож, урт хугацаанд үзүүлэх нөлөөлөл талаас нь авч үзэж байгаасай гэж би хүсэх байна.

Дөрөвдүгээрт, төв банкны хараат бус байдалтай холбоотой асуудал байна. Дэлхийн төв банкууд анхнаасаа хараат бус байсангүй. Харин цаг хугацаа өнгөрөхийн хэрээр төв банкныг Засгийн газрын харъяанаас гаргах нь дэлхий нийтийн хандлага болжээ. Төв банкны үйл ажиллагаа улс төрчдийн мэдэлд байсан цагт ДНБ-ий өсөлт тогтворждоггүй төдийгүй инфляци дорвитой буурдаггүй нь нэгэнт нотлогдсон зүйл. Гэтэл манайд дэлхий нийтийн хандлагыг сөрж, бусдын алдаанаас суралцахыг хүсэхгүй байгаа үзэгдэл илэрч буй нь харамсалтай.

Аливаа төв банк бол зөвхөн нийгмийн эрх ашигт үйлчилж байх үүрэгтэй институт юм. Харин энэхүү өндөр үүрэг хариуцлагыг ёс төртэй биелүүлэх баталгаа нь төв банкны хараат бус үйл ажиллагаа билээ. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс төв банк зарим тохиолдолд хүнд хэцүү арга хэмжээг зайлшгүй авах ёстой болдог. Ийм тулгамдсан арга хэмжээг цаг алдалгүй авч чаддаг байхын тулд төв банк хэнээс ч хараат бусаар шийдвэрээ гаргаж байх зайлшгүй шаардлага урган гардаг. Гэтэл үүнийг сүүлийн үед зарим УИХ-ын гишүүн хүртэл үгүйсгэж ярих болсныг анхаарахгүй орхиж болохгүй юм. Хариуцлагагүй улс төрд үйлчилж буй мөнгөний бодлого юунд хүргэдгийг Зимбабве улсын жишээнээс тод харж болно.

Тавдугаарт, макро зохистой бодлогын хослолын тухай хэдэн үг хэлмээр байна. Сүүлийн жилүүдэд төсөв хэтэрхий тэлж, мөнгөний бодлого төсвийн үүдэлтэй инфляцийг хязгаарлах бодлого явуулж байна. Энэ нь төсвөөс халамж тараан инфляцийг өдөөх, гаднаас орж буй валютын урсгалаар хилийн чанадад үйлдвэрлэгдсэн барааны хэрэглээг тэтгэх байдлыг бий болгож байна.

Мөнгөний бодлого чангарсны улмаас хувийн салбарын өсөлт удаашрах, зээлийн хүү буурахгүй байхад хүргэж байна.

Өнөөдөр АНУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, төсвийн хямралын үр нөлөө цаашид хэрхэх нь төдийлөн тодорхой бус байна. Европын холбооны улсуудын төсвийн өрөөс үүдэлтэй хүндрэл цаашид өргөжих магадлал ч байна.

Дэлхийн 2 дахь эдийн засаг болох Хятад улс инфляци, үнийн өсөлтийн улмаас өсөлтөө сааруулах арга хэмжээ авч байна.

Дэлхийн 3 дахь эдийн засаг Япон улсын эдийн засаг зогсонги байна. Нэг үгээр хэлэхэд дэлхийн эдийн засгийн байдал тийм ч өөдрөг харагдахгүй байна. Ийм нөхцөлд төсвийн мөчлөг сөрсөн бодлого, өнгөрсөн хямралын гол сургамж болсон макро зохистой бодлогын хослолд аль болох эрт шилжих хэрэгтэй байна.

Эцэст нь би өнөөдрийн арга хэмжээнд амжилт хүсэн ерөөхийн зэрэгцээ сэтгүүлчид та бүхнийг манай захирлуудтай ажил хэргийн, танил нөхдийн харилцаа холбоо тогтоогоорой гэж хүсэх байна. Та бид бүгд л Монгол улсын хөгжил дэвшлийн төлөө хөдөлмөрлөж яваа хүмүүс. Бид хүчээ нэгтгэж чадвал хүчирхэг Монгол улсыг байгуулж чадна.

Анхаарал тавьсанд баярлалаа.